

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/005/-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)  
Архангай аймаг  
2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)  
Ахлах аудитор Э.Нямсүрэн  
Утас: 9962-9111  
Цахим хаяг: [nyamsurene@audit.gov.mn](mailto:nyamsurene@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Аудитын санал дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.13 № 147

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЙРХАН ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ДАРГА Х.БАТЗАЯА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт тайлан, мөнгөн гүйлгээний тайлан санхүүгийн тайлангийн тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт урдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайлант онд тус хуулийн этгээд нь нийт 53,232.8 мянган төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй,
2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан орлого 25,124.8 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
3. Тайлант онд 7,267.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Дээрх 85,624.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Хайрхан сумын ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан "Хайрхан хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9.1 дэх заалтыг зөрчсөн ба тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/
Д/д	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	857,329.92	750,506.32
1.1.2	Дансны авлага	5,397,076.17	4,174,770.33
12011001	Дансны авлага байгууллага ₮	3,203,534.00	3,080,486.01
12011002	Дансны авлага хувь хүн ₮	2,193,542.17	1,094,284.32
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	27,888.20	3,092,263.00
12021003	НДШ-н авлага	27,888.20	3,092,263.00
1.1.6	Бараа материал	39,830,312.57	25,083,150.57
14011001	Бараа материал	39,830,312.57	25,083,150.57
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>46,112,606.86</b>	<b>33,100,690.22</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	77,930,538.17	70,298,684.64
20011002	Барилга, байгууламж	14,700,000.00	14,700,000.00
20011003	Машин, тоног төхөөрөмж	61,524,800.00	62,880,000.00
20011005	Тавилга, эд хогшил	1,999,000.00	1,999,000.00
20011007	Бусад үндсэн хөрөнгө	16,291,000.00	16,434,000.00
20021002	Барилга, байгууламж хуримтлагдсан элэгдэл	(553,277.68)	(920,777.68)
20021003	Машин, тоног төхөөрөмж хуримтлагдсан элэгдэл	(11,774,448.73)	(18,577,213.34)
20021005	Тавилга, эд хогшил хуримтлагдсан элэгдэл	(566,931.67)	(766,831.67)
20021007	Бусад үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдэл	(3,689,603.75)	(5,449,492.67)
1.2.2	Биет бус хөрөнгө	770,283.06	560,503.06
21011002	Компьютерийн програм хангамж	500,000.00	500,000.00
21011008	Бусад биет бус хөрөнгө	548,900.00	548,900.00
21021002	Компьютерийн програм хангамж хуримтлагдсан хорогдол	(60,821.92)	(160,821.92)
21021008	Бусад биет бус хөрөнгө хуримтлагдсан хорогдол	(217,795.02)	(327,575.02)
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>78,700,821.23</b>	<b>70,859,187.70</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>124,813,428.09</b>	<b>103,959,877.92</b>
2.1.1.1	Дансны өглөг	82,075,923.15	36,086,480.00
31011001	Дансны өглөг ₮	82,075,923.15	36,086,480.00
2.1.1.2	Цалингийн өглөг	1,392,506.00	-
33011001	Цалингийн өглөг	1,392,506.00	-
2.1.1.3	Татварын өр	15,529,657.38	17,146,305.53
34011001	ААНОАТ-ын өглөг	1,442,006.84	2,039,664.88
34011002	НӨАТ-ын өглөг	14,087,650.54	14,858,920.65
34011016	Агаарын бохирдлын төлбөрийн өглөг	-	247,720.00

**Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.1.1.8	Урьдчилж орсон орлого	3,533,658.17	-
32011001	Урьдчилж орсон орлого	3,533,658.17	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>102,531,744.70</b>	<b>53,232,785.53</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>102,531,744.70</b>	<b>53,232,785.53</b>
2.3.9	Хуримтлагдсан ашиг	22,281,683.39	50,727,092.39
46011001	Хуримтлагдсан ашиг, алдагдал	22,281,683.39	50,727,092.39
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>22,281,683.39</b>	<b>50,727,092.39</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>124,813,428.09</b>	<b>103,959,877.92</b>

**2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан**

			/төгрөгөөр/
Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
<b>01</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>296,222,954.54</b>	<b>375,585,932.88</b>
51011001	Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого	289,232,389.19	372,052,274.71
51011011	Ажил, үйлчилгээ үзүүлсний орлого	6,990,565.35	3,533,658.17
<b>03</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>296,222,954.54</b>	<b>375,585,932.88</b>
09	Борлуулалт, маркетингийн зардал	223,428,616.01	205,575,336.66
71011003	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	180,000.00	410,000.00
71011005	Бичиг хэргийн зардал	-	31,363.30
71011006	Шуудан холбооны зардал	27,272.73	-
71011007	Мэргэжлийн үйлчилгээний зардал	5,530,000.00	5,000,000.00
71011008	Сургалтын зардал	-	85,000.00
71011011	Ашиглалтын зардал	202,336,039.74	189,688,985.34
71011012	Засварын зардал	290,000.00	2,322,647.96
71011016	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	3,000,000.00	3,037,785.52
71011017	Тээврийн зардал	222,936.36	-
71011018	Шатахууны зардал	10,317,367.18	4,999,554.54
71011030	Бусад зардал	1,525,000.00	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	127,562,504.12	149,081,675.93
70011001	Ажилчдын цалингийн зардал	92,253,595.54	104,385,853.31
70011002	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	15,496,315.78	18,329,708.42
70011003	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	120,000.00	3,026,657.48
70011004	Томилолтын зардал	-	660,000.00
70011005	Бичиг хэргийн зардал	271,272.50	1,122,480.84
70011006	Шуудан холбооны зардал	226,540.64	-
70011007	Мэргэжлийн үйлчилгээний зардал	-	3,000,000.00
70011011	Ашиглалтын зардал	909,090.91	2,433,718.19
70011012	Засварын зардал	1,200,973.85	6,171,595.57

**Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

70011013	Элэгдэл, хорогдлын зардал	9,359,260.35	9,495,162.12
70011016	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	1,100,000.00	256,500.00
70011018	Шатахууны зардал	421,454.55	-
70011030	Бусад зардал	6,204,000.00	200,000.00
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	6,037,250.00	27,600.00
74011001	Алданги, торгуулийн зардал	6,000,000.00	-
74011006	Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал	24,400.00	27,600.00
74011015	Бусад зардал - хасагдахгүй	12,850.00	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(504,671.41)
54011002	Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз	-	504,671.41
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(60,805,415.59)</b>	<b>20,396,648.88</b>
19	Орлогын татварын зардал	-	2,039,664.88
91011001	Орлогын татварын зардал	-	2,039,664.88
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(60,805,415.59)</b>	<b>18,356,984.00</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн ашиг (алдагдал)</b>	<b>(60,805,415.59)</b>	<b>18,356,984.00</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	<b>-</b>	<b>280,000.00</b>
23.3	Бусад олз (гарз)	-	280,000.00
52021021	Бусад татвар ногдох орлогод орохгүй олз	-	280,000.00
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(60,805,415.59)</b>	<b>18,636,984.00</b>

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>1</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-	-	-	-	<b>22,281,683.39</b>	<b>22,281,683.39</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	9,808,425.00	9,808,425.00
3	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-	-	-	-	-	-	18,636,984.00	18,636,984.00
<b>4</b>	<b>2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	-	-	-	-	-	-	<b>50,727,092.39</b>	<b>50,727,092.39</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант үеийн дүн
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>325,775,596.00</b>	<b>409,765,094.74</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	325,775,596.00	409,485,094.74
1.1.6	Бусад мөнгөн орлого	-	280,000.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>325,131,443.49</b>	<b>407,713,718.34</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	75,061,747.49	88,105,662.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	26,039,670.17	33,353,750.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	147,075,560.00	185,218,995.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	36,432,465.68	49,756,254.84
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	13,179,070.00	6,022,700.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	15,304,530.15	32,691,036.50
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	12,038,400.00	12,565,320.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>644,152.51</b>	<b>2,051,376.40</b>
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>550,000.00</b>	<b>2,158,200.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	550,000.00	2,158,200.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(550,000.00)</b>	<b>(2,158,200.00)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>94,152.51</b>	<b>(106,823.60)</b>
<b>6</b>	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ</b>	<b>763,177.41</b>	<b>857,329.92</b>
<b>7</b>	<b>МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>857,329.92</b>	<b>750,506.32</b>

## 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар 9,808.4 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Үр дүнгийн тайланд нэмэгдсэн өртгийн албан татварыг суутган авсан 9,808,4 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтын олз дансанд тайлагнасныг хуримтлагдсан ашиг дансанд бүртгүүлж аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй 60,499.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 4 албан шаардлага хүргүүлээ.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн 85,624.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 81,868.3 мянган төгрөгөөр их, шинж чанарын хувьд материаллаг тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

**3.1.1** Тус хуулийн этгээд нь тайлангийн жилд 7,267.0 мянган төгрөгийн авлагатай ажилласнаас 4,174.7 мянган төгрөг нь айл өрх, аж ахуй нэгжийн халаалтын, 3,092.3 мянган төгрөг нь Нийгмийн даатгалын илүү төлөлтийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагаа хүргүүлэх.

**3.1.2** Тайлант онд 53,232.8 мянган төгрөгийн өр төлбөрийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагаа хүргүүлэх

**3.1.3** Нийт орлогыг 400,990.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 375,865.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 6.3 хувиар буюу 25,124.8 мянган төгрөгөөр тасалсан буюу дутуу бүрдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Хайрхан хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ - ын дүрмийн 6.9.1-д "Холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх, ажил зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагаа хүргүүлэх

**3.1.4** Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлан боловсруулж байгаа Dayansoft программ нь Сангийн яамны нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн программ хангамжийн жагсаалтад ороогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2- д Жижиг, дунд аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлагналын олон улсын стандарт; 17.1.11 " Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамж" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагаа хүргүүлэх

Хайрхан сумын “Хайрхан хөгжлийн дэд бүтэц” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл													
Алдааны товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс:										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо					Дүн
Авлага үүсгэсэн	1	7,267.0			1	7,267.0							
Өр төлбөр	1	53,232.8			1	53,232.8							
Орлогын төлөвлөгөө	1	25,124.8			1	25,124.8							
Программ хангамж	1	-			1	-							
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>85,624.6</b>			<b>4</b>	<b>85,624.6</b>							

